НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

## Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/244/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: М.Ундармаа<br>Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn<br><br>Аудитор: Л.Одонтуяа<br>Утас: 325093 Цахим хаяг: odontuyal@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....**Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.... **Error! Bookmark not defined.**
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.... **Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.... **Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд **Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН....**Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл .... **Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал.... **Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ... **Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт. **Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.... **Error! Bookmark not defined.**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....24

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НТАГ | Нийслэл дэх төрийн аудитын газар |
| НТГ | Нийслэлийн татварын газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| АТӨЯХАТ | Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| ЧД | Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар |
| ТЖАХ | Төрийн жинхэнэ албан хаагч |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 238

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.БАТЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж, Нийслэлийн Татварын газраас шилжүүлсэн 24.4 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас 98.7 сая төгрөг нийт 132.1 сая төгрөгийн эх үүсвэрийг татварын орлого бүрдүүлэх үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн хөрөнгө оруулалтаар 253.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилгыг 34.4 сая төгрөгийн хангамжийн материалыг, Татварын ерөнхий газраас 53.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлж авснаар ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулсан байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **168,916,335.56** | **214,379,926.21** |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **17,031,035.21** |
| **335** | **Бусад авлага** | 0.00 | 17,031,035.21 |
| **3351** | **Байгууллагаас авах авлага** | 0.00 | 17,031,035.21 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **168,916,335.56** | **197,348,891.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **168,916,335.56** | **197,348,891.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 11,790,632.50 | 3,158,810.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 66,115,617.06 | 53,453,440.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 91,010,086.00 | 140,736,641.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **267,711,526.49** | **522,471,749.01** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **267,711,526.49** | **522,471,749.01** |
| **392** | **Биет хөрөнгө** | **267,474,404.46** | **522,471,749.01** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 38,800,000.00 | 38,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -38,800,000.00 | -38,800,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 313,211,857.15 | 480,578,393.17 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -246,771,754.24 | -151,414,160.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 231,149,255.00 | 248,749,005.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -30,114,953.45 | -55,441,488.77 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **237,122.03** | **0.00** |
| 39301 | Программ хангамж | 957,000.00 | 957,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -719,877.97 | -957,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **436,627,862.05** | **736,851,675.22** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **436,627,862.05** | **736,851,675.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **436,627,862.05** | **736,851,675.22** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | 330,107,832.99 | 330,107,832.99 |
| 51101 | Өмч: - төрийн | 330,107,832.99 | 330,107,832.99 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **105,665,934.48** | **405,889,747.65** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -100,053,826.49 | 105,665,934.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 205,719,760.97 | 300,223,813.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 854,094.58 | 854,094.58 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **436,627,862.05** | **736,851,675.22** |

## 2.2 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,254,043,859.00** | **4,224,972,780.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **241,334,359.00** | **410,645,916.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **241,334,359.00** | **410,645,916.32** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 237,624,359.00 | 393,255,916.32 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 172,904,000.00 | 333,227,481.32 |
| 1200046 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 64,720,359.00 | 60,028,435.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 3,710,000.00 | 17,390,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,012,709,500.00** | **3,814,326,864.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **3,812,209,500.00** | **3,682,226,864.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,812,209,500.00 | 3,682,226,864.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,500,000.00** | **132,100,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,500,000.00 | 132,100,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,047,981,168.07** | **3,924,748,967.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,047,981,168.07** | **3,924,748,967.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,982,832,633.68** | **3,625,669,250.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,933,874,128.13** | **2,843,470,936.38** |
| 210101 | Үндсэн цалин | 1,505,861,324.61 | 1,558,594,721.73 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 502,325,261.72 | 559,385,386.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 259,701,730.06 | 313,875,629.87 |
| 210104 | Урамшуулал | 665,985,811.74 | 411,615,197.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **367,361,519.18** | **386,343,300.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 252,658,528.12 | 269,814,057.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,724,533.16 | 29,790,437.52 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 14,618,066.68 | 14,786,044.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,072,078.43 | 14,427,183.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 56,288,312.79 | 57,525,577.03 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **411,162,504.00** | **61,467,767.97** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 0.00 | 15,173,636.94 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 7,939,553.03 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 4,091,036.33 |
| 210304 | Байрны түрээс | 411,162,504.00 | 34,263,541.67 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **86,102,890.98** | **55,919,599.56** |
| 210401 | Бичиг хэрэг | 60,906,827.50 | 28,532,952.50 |
| 210402 | Тээвэр шатахуун | 6,300,000.00 | 5,400,000.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 14,511,702.92 | 8,151,414.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 2,170,367.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,384,360.56 | 11,664,866.06 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,600,000.00** | **18,977,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,600,000.00 | 18,977,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **81,898,480.00** | **127,292,814.57** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 81,610,180.00 | 126,827,914.57 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 197,100.00 | 197,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,200.00 | 245,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **93,833,111.39** | **132,197,831.80** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,337,816.27 | 35,634,120.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 640,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 60,855,295.12 | 96,563,711.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **65,148,534.39** | **299,079,716.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **36,503,030.00** | **89,835,452.78** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,289,780.00 | 86,799,452.78 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,213,250.00 | 3,036,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **28,645,504.39** | **209,244,264.09** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,645,504.39 | 209,244,264.09 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **206,062,690.93** | **300,223,813.17** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **342,929.96** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 342,929.96 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -342,929.96 | 0.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 205,719,760.97 | 300,223,813.17 |

## 2.3 Аудит хийсэн 2025 оны мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 4,012,709,500.00 | 3,814,466,864.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 0.00 | 140,000.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 0.00 | 140,000.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 140,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 4,012,709,500.00 | 3,814,326,864.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,812,209,500.00 | 3,682,226,864.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,812,209,500.00 | 3,682,226,864.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 200,500,000.00 | 132,100,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,500,000.00 | 132,100,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,012,709,500.00 | 3,813,620,411.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,012,709,500.00 | 3,813,620,411.00 |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,947,560,965.61 | 3,514,540,694.13 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,933,874,128.13 | 2,860,501,971.59 |
| 210101 | Үндсэн цалин | 1,505,861,324.61 | 1,421,747,427.78 |
| 210102 | Нэмэгдэл | 502,325,260.72 | 593,943,346.57 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 259,701,730.06 | 324,100,844.18 |
| 210104 | Урамшуулал | 665,985,812.74 | 520,710,353.06 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 367,361,519.18 | 386,343,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 252,658,528.12 | 269,814,057.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,724,533.16 | 29,790,437.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,618,066.68 | 14,786,044.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,072,078.43 | 14,427,183.36 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 56,288,312.79 | 57,525,577.03 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 411,162,504.00 | 61,467,767.97 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 15,173,636.94 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 7,939,553.03 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.00 | 4,091,036.33 |
| 210304 | Байрны түрээс | 411,162,504.00 | 34,263,541.67 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 89,008,774.30 | 43,886,650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 66,254,000.00 | 18,192,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,700,000.00 | 5,400,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,387,077.30 | 7,957,214.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 2,150,367.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,667,697.00 | 10,186,169.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,600,000.00 | 19,744,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 204,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,600,000.00 | 19,539,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 130,164,040.00 | 136,596,704.57 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 129,875,740.00 | 136,131,804.57 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 197,100.00 | 197,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 69,200.00 | 245,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 22,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,390,000.00 | 6,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 6,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,390,000.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 65,148,534.39 | 299,079,716.87 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,503,030.00 | 89,835,452.78 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,289,780.00 | 86,799,452.78 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,213,250.00 | 3,036,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 28,645,504.39 | 209,244,264.09 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,645,504.39 | 209,244,264.09 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | 0.00 | 846,453.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | 0.00 | 846,453.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 0.00 | 846,453.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 846,453.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.00 | 846,453.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | 0.00 | -846,453.00 |

## 2.4 Аудит хийсэн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 330,107,832.99 | 854,094.58 | -102,806,692.49 | 228,155,235.08 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 2,762,656.00 | 2,762,656.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 330,107,832.99 | 854,094.58 | -100,044,036.49 | 230,917,891.08 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 205,709,970.97 | 205,709,970.97 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 330,107,832.99 | 854,094.58 | 105,665,934.48 | 436,627,862.05 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 330,107,832.99 | 854,094.58 | 105,665,934.48 | 436,627,862.05 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 330,107,832.99 | 854,094.58 | 105,665,934.48 | 436,627,862.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 300,223,813.17 | 300,223,813.17 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 330,107,832.99 | 854,094.58 | 405,889,747.65 | 736,851,675.22 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,793,138,000.00** | **3,482,092,759.91** | 311,045,240.09 | 91.8% |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,793,138,000.00** | **3,482,092,759.91** | 311,045,240.09 | 91.8% |
| 210 | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,627,053,100.00** | **3,392,257,307.13** | 234,795,792.87 | 93.5% |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,037,833,800.00** | **2,860,501,971.59** | 177,331,828.41 | 94.2% |
| 210101 | Үндсэн цалин | 1,415,176,500.00 | 1,421,747,427.78 | -6,570,927.78 | 100.5% |
| 210102 | Нэмэгдэл цалин | 644,130,900.00 | 593,943,346.57 | 50,187,553.43 | 92.2% |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 255,635,500.00 | 324,100,844.18 | -68,465,344.18 | 126.8% |
| 210104 | Урамшуулал | 722,890,900.00 | 520,710,353.06 | 202,180,546.94 | 72.0% |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **386,343,300.00** | **386,343,300.00** | 0.00 | 100.0% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 264,341,400.00 | 269,814,057.29 | -5,472,657.29 | 102.1% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 30,535,100.00 | 29,790,437.52 | 744,662.48 | 97.6% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,258,300.00 | 14,786,044.80 | 472,255.20 | 96.9% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 15,241,700.00 | 14,427,183.36 | 814,516.64 | 94.7% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 60,966,800.00 | 57,525,577.03 | 3,441,222.97 | 94.4% |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **105,964,300.00** | **61,467,767.97** | 44,496,532.03 | 58.0% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 47,518,200.00 | 15,173,636.94 | 32,344,563.06 | 31.9% |
| 210302 | Түлш, халаалт | 16,801,600.00 | 7,939,553.03 | 8,862,046.97 | 47.3% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,380,900.00 | 4,091,036.33 | 3,289,863.67 | 55.4% |
| 210304 | Байрны түрээс | 34,263,600.00 | 34,263,541.67 | 58.33 | 100.0% |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **34,226,600.00** | **26,392,800.00** | 7,833,800.00 | 77.1% |
| 210401 | Бичиг хэрэг | 11,290,400.00 | 9,298,650.00 | 1,991,750.00 | 82.4% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 700,000.00 | 400,000.00 | 300,000.00 | 57.1% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,260,600.00 | 4,957,214.00 | 2,303,386.00 | 68.3% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,993,600.00 | 2,150,367.00 | 843,233.00 | 71.8% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,982,000.00 | 9,586,569.00 | 2,395,431.00 | 80.0% |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,639,500.00** | **20,590,753.00** | 48,747.00 | 99.8% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,100,000.00 | 1,051,253.00 | 48,747.00 | 95.6% |
| 210604 | Урсгал засвар | 19,539,500.00 | 19,539,500.00 | 0.00 | 100.0% |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **42,045,600.00** | **36,960,714.57** | 5,084,885.43 | 87.9% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,081,700.00 | 36,495,814.57 | 4,585,885.43 | 88.8% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 197,100.00 | 197,100.00 | 0.00 | 100.0% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 314,700.00 | 245,800.00 | 68,900.00 | 78.1% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 71,800.00 | 22,000.00 | 49,800.00 | 30.6% |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **166,084,900.00** | **89,835,452.78** | 76,249,447.22 | 54.1% |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **166,084,900.00** | **89,835,452.78** | 76,249,447.22 | 54.1% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 163,048,900.00 | 86,799,452.78 | 76,249,447.22 | 53.2% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,036,000.00 | 3,036,000.00 | 0.00 | 100.0% |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **3,793,138,000.00** | **3,482,092,759.91** | 311,185,240.09 | 91.8% |
| 1310 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **3,793,138,000.00** | **3,482,092,759.91** | 311,185,240.09 | 91.8% |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,793,138,000.00 | 3,482,092,759.91 | 311,185,240.09 | 91.8% |

## 2.6 Аудит хийсэн 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **132,100,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **132,100,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **123,129,840.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **17,493,850.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,894,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 599,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **99,635,990.00** |
| **210801** | **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | 99,635,990.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **6,000,000.00** |
| **210901** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **8,970,160.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 8,970,160.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **132,100,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **132,100,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 132,100,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 20,6485.2 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

**Залруулсан алдаа:**

- Үр дүнгийн тайланд 3,984.2 мянган төгрөгийн зардал бууруулах гүйлгээ хийсэн байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй 16,664.0 мянган төгрөгийн орлогыг өөрийн орлогоор тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НБББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д “*Иж бүрэн байх- санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх*”, санхүүгийн тайлагналын“*тохиолдсон байх*”, “*толилуулга*” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 53,359.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 23,750.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 29,609.1 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 53,359.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,360.6 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

**3.1 Албан шаардлага**

1. Үйл ажиллагааны чиглэлээс өөр байгууллагаас 23,750.0 мянган төгрөгийн бараа үйлчилгээ худалдан авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "*үнэн зөв байх",* Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "*Хариуцлагатай байх*", 16 дугаар зүйлийн 16.1.1-т "*төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах*", 16.5.2-т "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "*үнэн зөв байх"* батламж мэдэгдлийн хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Улсын бүртгэлд бүртгэгдсэн үйл ажиллагааны чиглэл тохироогүй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, санхүүжилт олгосон зөрчлийг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

**3.2 Зөвлөмж**

1. Сургалт сурталчилгаа зохион байгуулахад 2,691.8 мянган төгрөгөөр цай, кофе, ус, ундаа авч зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалтай тус тус нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах.

2. Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах",* 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", ТЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дүгээр тушаалтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*үнэн зөв байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Албан хаагчийг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу ажиллуулах.

3. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 3 ширхэг 26,917.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;*", 20.2.4-т "*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;*", Сангийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*"-ын 10 дугаар зүйлийн 10.1-т "*Үндсэн хөрөнгө нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм*" гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийг холбогдох данс бүртгэлд тусгаж, элэгдлийг нөхөн тооцох.

4. Цалингийн баримтыг архивын нэгж болгож архивлаагүй байна. Энэ нь Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "*архивын баримт" гэж архивт байнга болон түр хугацаагаар хадгалагдаж байгаа бүх төрлийн баримтыг;"* 44 дүгээр зүйлийн 44.3-т "*Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баримт нягтлан шалгах комиссын хурлаар хэлэлцүүлсний дараа байгууллагын удирдлагаар батлуулж, оны эхнээс мөрдөж ажиллана.*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Цалингийн баримтыг, харилцах дансны баримтаас салгаж холбогдох хууль, журмын дагуу архивлаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн тайланд зардал бууруулах гүйлгээ хийсэн | 1 | 3,984.2 | - | - | 1 | 2,779.7 | 1 | 2,779.7 | - | - | - | - |
| Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй орлогыг орлогоор тайлагнасан | 1 | 16,664.0 | - | - | 1 | 16,664.0 | 1 | 16,664.0 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **20,648.2** | **-** | **-** | **2** | **20,648.2** | **2** | **20,648.2** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн баримтыг архивын нэгж болгож тусд нь архивлаагүй | 1 | 0.00 | | | | | 1 | 0.00 |
| Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 3 ширхэг хөрөнгийг бүртгэсэн байна. | 1 | 26,917.3 | | | | | 1 | 26,917.3 |
| Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байна. | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Үйл ажиллагааны чиглэлээс өөр байгууллагаас бараа үйлчилгээ худалдан авсан. | 1 | 23,750.0 | | | 1 | 23,750.0 | | |
| Сургалт, сурталчилгааны арга хэмжээнд цай, кофе авч зарцуулсан байна. | 1 | 2,691.8 | | | | | 1 | 2,691.8 |
| Дүн | **5** | **53,359.1** | - | - | **1** | **23,750.0** | 2 | **29,609.1** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийн санд 5 саяас дээш орлого, зарлагын нийт 51 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Үндсэн үйл ажиллагааных нь зардлыг улсын төсвөөс баталж өгсөн байхад үндсэн чиг үүргээ хэрэгжүүлснийхээ төлөө орон нутгийн төсвөөс давхардуулан санхүүжилт авч зарцуулсан байна. | 1 | 123,129.8 | | | - | - | 1 | 123,129.8 |
| Дүн | **2** | **123,129.8** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **123,129.8** |